

МОНГОЛ ХЯТАДЫН ХАРИЛЦАА:  
ЗҮҮН ХОЙТ АЗИЙН ОЛОН УЛСЫН  
ХАРИЛЦААНД ЭЗЛЭХ БАЙР

Л.Хайсандай\*

Манай хоёр орон өнө удаан жил хаяа хаяагаа дэрлэн айлсаж ирэхдээ улс төр, эдийн засаг, үндэсний соёл болон нийгмийн байгууллын эрх ашгийн үүднээс түүхийн тодорхой үе шатуудад янз бүрийн харилцаатай байжээ. Түүгээр ч үл барам хоёр орон түүхэн тодорхой зарим үед нэгэн их гүрний хүрээнд багтаж оршиж байсан ч удаатай. Хэдий тийм авч Монгол, Хятад хоёр бол угаасаа хэл, соёл, зан заншил, ахуй амьдрал зэрэг олон зүйлээрээ эрс ялгаатай, тус тусдаа бие даасан хоёр ондоо (аль нэгнийхээ салшгүй бэрэлдэхүүн хэсэг болж байгаагүй) улс байсныг буурал түүх гэрчлэнэм билээ. Чухамдаа 1949 оны аравдугаар сард хятадад ардын хувьсгал ялж, БНХАУ байгуулагдсанаар

---

\* Л.Хайсандай. Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, дэд доктор

дорно дахины ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцэлд бас нэг түүхэн чухал үйл явдал гарсан юм. Манай улс БНХАУ-ыг байгуулагдсан даруйд нь хүлээн зөвшөөрсөн билээ.

Чингэж БНХАУ байгуулагдаж, манай хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосноор Монгол, Хятадын харилцааны олон зууны түүхэнд цоо шинэ хуудас нээж, Монгол улс, БНХАУ-ын хооронд бүх талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн бололцоо бүрдсэн юм.

Харилцан туслах, дэмжих явдал тэр үеийн Монгол, Хятадын харилцааны онцгой шинж байлаа. Тухайлбал, анх 1956 онд БНХАУ-ын Засгийн газар монгол улсад 160 сая рублийн (хуучин ханшаар) буцалтгүй тусламж үзүүлсэн бөгөөд 1956-1959 онд БНХАУ-ын тусламжаар монголд аж үйлдвэр, хөдөө аж ахуй, тээвэр, соёлын салбарын хэд хэдэн чухал объект байгуулсан юм. Түүнээс гадна төрөл бүрийн мэргэжлийн инженер техникийн ажилтан, тусгай мэргэжлийн олон мянган ажилчныг Монголын засгийн газрын хүсэлтээр түр ирүүлж, тус орны үйлдвэр, хөдөө аж ахуйн барилгууд дээр ажиллуулж байлаа. Монголын засгийн газар, ард түмэн БНХАУ-ын Засгийн газарт тийнхүү тусламж үзүүлсэн явдалд тухай бүрд нь гүн талархал илэрхийлж, хятад иргэдийн ажил үйлсийг өндрөөр үнэлж байв.

Монгол, Хятадын харилцаанд худалдаа нь олон жилийн түүхэн уламжлалтай бөгөөд дурьдан буй үед хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны хамгийн чухал үзүүлэлтүүдийн нэг байлаа.

1953 оны дөрөвдүгээр сард БНМАУ, БНХАУ-ын хооронд харилцан бараа нийлүүлэх, төлбөрийн тухай анхны хэлэлцээрт гарын үсэг зурсан. Хоёр орны хоорондох худалдааны эргэлт 6 жилийн дотор (1951-1956) бараг 8 дахин нэмэгдсэн бөгөөд 1959 онд 1952 оныхоос 34.6 дахин нэмэгдсэн<sup>1</sup>. 1959 он гэхэд БНМАУ-ын гадаад худалдааны нийт эргэлтэд БНХАУ нь тэр үеийн ЗСБНХУ-ын дараа хоёрдугаар байр буюу хувийн жингээрээ 15.5%-ийг эзэлж байв<sup>2</sup>.

1956 оноос Москва, Улаанбаатар, Бээжинг холбосон төмөр замыг монголын нутгийг дайруулан байгуулж, ашиглалтад оруулсан нь зорчигчид, барааг шуурхай тээвэрлэх, өрнө, дорнын бусад улсад нэвтрэх таатай боломж нээсний зэрэгцээ хөрш гурван орны аж ахуй, соёлын байгуулалт, найрамдалт харилцаанд бодитой нөлөө үзүүлж эхэлсэн юм<sup>3</sup>.

Тийнхүү Монгол, Хятадын харилцааны эхний 10 жилийг хоёр орны найрамдалт харилцааны эрх ашигт нийцсэн үе гэж авч үзэх бүрэн үндэстэй бөгөөд тэрхүү харилцаа нь харилцан үр ашигтай байв.

1960 онд Улаанбаатар хотноо Монгол, Хятадын харилцааны үндсэн зарчим, тухайлбал: төрийн тусгаар тогтнол ба газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, тэгш эрх, харилцан ашигтай байх зарчмыг нарийн заан тодорхойлсон "Найрамдал, харилцан туслах тухай Гэрээ"-нд гарын үсэг зурсан юм. Энэ гэрээний үзэл санаа, зарчмыг тодорхой ажил хэрэг болгон тус хоёр орны хооронд 1962 оны арван хоёрдугаар сард Хилийн гэрээ байгуулж, түүнийхээ дагуу хилээ тогтоосон билээ.

Чингэж хоёр орны харилцааны түүхэнд улирч ирсэн хилийн холбогдолтой нарийн төвөгтэй чухал асуудлууд "эвийн" шугамаар шийдвэрлэгдсэн юм. Энэ нь дэлхийн улс онуудын хоорондын харилцааны түүхэнд хилийн асуудлаар санал нийлэн тохиролцоонд нэг их түвэгтэй биш хүрсэн ховор үзэгдэл, үйл явдлын нэг болов.

Гэвч 1950-иад оны сүүлч, 60-аад оны эхээр Монгол, Хятадын харилцаанд сөрөг хандлага, зохисгүй үзэгдлүүд гарах болсон юм. БНХАУ, хуучин ЗХУ-ын нам, төрийн удирдлагаас олон улсын тавцан

дээр болон Монгол улсын талаар баримталж байсан бодлого, үйл явууллагын шууд үр дагавар, түүнчлэн бас Монголын удирдлагын зүгээс тэр үед явуулдаг байсан хэт өрөөсгөл, зөвхөн нэг талыг (тухайлбал Зөвлөлтийг) аялдан дагасан улс төрийн үйл ажиллагааны нэгэн тод илрэл мөн байв гэлтэй.

Харин ХКН-ын Төв Хорооны III бүгд хурлаас (1978 оны) дэвшүүлсэн чиг шугам, шийдвэрийн дагуу БНХАУ наяд оны эхэн үеэс эдийн засгийн шинэтгэлийг эрчимтэй хэрэгжүүлж, гадаадад нээлттэй бодлого явуулан дэлхийн улс орнууд, түүний дотор өөрийн хөршүүдтэй харилцаагаа хэвийн болгон хөгжүүлэх чиглэл баримтлах болов. Энэ нь жижиг монголын хувьд үлэмж чухал ач холбогдолтой хандлага байв. Ийм шинэ нөхцөл байдлын дүнд, мөн хоёр талын идэвх санаачлага, хүч чармайлтын үрээр Монгол-Хятадын хооронд төр, олон нийтийн байгууллагуудын харилцаа, хэлхээ холбоо сэргэж, худалдаа эдийн засаг, соёл шинжлэх ухааны хамтын ажиллагаа өргөжин хөгжих болсноор хоёр орны харилцааны шинэ үе шат эхлэв.

Энэ бүхнээс үүдэн хоёр орны орчин үеийн харилцааны замналыг нэгтгэн гаргаж, уг харилцааны 1949 оноос эдүгээ хүртлэх үеийг онцлог шинжээр нь гурван үед тоймлон хувааж болно гэж бид үзэж байна. Үүнд Нэгд, 1949-1950-иад оны сүүлч буюу БНМАУ, БНХАУ-ын бүх талын харилцаа хэвийн хөгжиж, хоёр орны хооронд ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагаа гүнзгийрэн энэ нь Монгол, Хятадын ард түмний эрх ашигт, улмаар Ази болон дэлхий дахины энх тайвны үйл хэрэгт нийцэж байсан үе: хоёрт, 1960-аас 1970-аад оны сүүлч буюу хоёр улсын тухайн үеийн удирдлагаас олон улсын харилцаанд болон улс орныхоо дотоодод явуулсан "өвөрмөц" бодлогын улмаас хоёр орны харилцаа олон талаар муудаж, зогсонги байдалд орсон үе; гуравт, 1980-аад оны эхнээс Монгол, Хятадын харилцааг сайжруулах талаар үлэмж ахиц гарч, улмаар хэвийн болж хөгжин гүнзгийрч эхэлсэн үе зэрэг болно. Тийнхүү 1980-аад оны дунд үеэс Монгол, Хятадын харилцаа хэвийн болох тийш эргэж, төр засаг, олон нийтийн байгууллагуудын хооронд харилцан төлөөлөгчид солилцох явдал идэвхжин тогтмолжиж, соёл, шинжлэх ухаан, худалдаа, эдийн засгийн харилцаа жилээс жилд өргөжих хандлагатай болов.

1986 оны 4 дүгээр сард гарын үсэг зурсан 1986-1990 оны худалдааны таван жилийн хэлэлцээр ёсоор 1990 онд хоёр талын худалдааны нийт эргэлтийн хэмжээ 51.4 сая швейцар франкад хүрч<sup>4</sup>, Монгол улс зүсмэл банз, адууны шир, тарваганы арьс, бугын цусан эвэр зэргийг экспортлож, даалимба, торго, алим, жимс, халуун сав, үзэг, будаг гэх зэрэг бүтээгдэхүүн импортоор авчээ.

Мөн үед хилийн худалдаа болон шууд бараа солилцоо эрчимтэй хөгжиж эхэллээ. Зөвхөн 1988-1989 онд гэхэд БНХАУ-ын ӨМӨЗО, Синьзян-Уйгарын ӨЗО-той хилийн худалдаа хийх гэрээнд гарын үсэг зурж, 47 сая шв.франкийн бараа солилцохоор тохирчээ<sup>5</sup>.

Монгол улсын худалдаа, эдийн засгийн төлөөлөгчид 1989 оны хавар ӨМӨЗО-нд очиж тус ӨЗО-ны холбогдох байгууллагын хүмүүстэй хэлэлцээ хийж, худалдаа, эдийн засгийн эрх бүхий байгууллагуудын хооронд, бараа материал солилцох, эдийн засаг, техникийн хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэхээр тохиролцжээ.

БНХАУ-ын Засгийн газраас Монголын Засгийн газарт 1958, 1960 онуудад олгосон зээл, түүний хүүг төлөх талаар хэлэлцээ хийж, холбогдох протоколд 1986 оны 1 дүгээр сарын 15-нд гарын үсэг зурснаар олон жил шийдэгдээгүй байсан асуудлыг шийдвэрлэв.

Төмөр замын ачаа тээврийн талаар хэлэлцээр байгуулж, хамтын

ажиллагаагаа улам хөгжүүлэх болов. Түүний зэрэгцээ Монголын иргэний агаарын тээврийг удирдах ерөнхий газар, Улаанбаатар-Бээжингийн агаарын нислэгийг 1986 онд сэргээн цаашид тогтмол нислэг хийж эхэлсэн нь тус хоёр орны хоорондох зорчигч тээврийн харилцаа, олон улсын жуулчлалыг хөгжүүлэхэд таатай нөхцөл бүрдүүлсэн билээ.

Мөн соёл, шинжлэх ухаан-техникийн болон бусад олон салбарт хамтран ажиллах явдал идэвхжиж эхэлснийг дурьдалтай. Жишээлбэл: 1986 оноос хоёр орны хооронд нэг, хоёр жилийн хугацаатай соёлын төлөвлөгөөнд гарын үсэг зурж, түүний дагуу урлагийн хамтлагууд айлчлан тоглох, уран зураг, гар урлалын үзэсгэлэн гаргах, зохиолч, эрдэмтэн, тамирчид харилцан айлчлах зэрэг төрөл бүрийн ажил, арга хэмжээнүүд зохиогдож байна. Уг төлөвлөгөө ёсоор адил тооны мэргэжилтэн багш, оюутан, мэргэжил дээшлүүлэгч харилцан илгээж, уран сайхны болон баримтат кино, ном хэвлэл, дуу хөгжмийн бичлэг солилцож эхэлжээ.

Монгол, Хятадын харилцаа бүх талаар ийнхүү сэргэн идэвхжиж эхэлсэн үе буюу 1989 оны хавар Монгол улсын Гадаад харилцааны сайд БНХАУ-д, мөн оны намар БНХАУ-ын Гадаад явдлын яамны сайд Монгол улсад тус тус харилцан айлчилж, үр дүнтэй яриа хэлэлцээ хийсэн нь манай хоёр орны ард түмний язгуур эрх ашигт зүй ёсоор нийцсэн юм.

90-ээд оны эхэн гэхэд манай хоёр улсын харилцаа олон талаар хэвийн болж, цаашид төрөл бүрийн салбарт харилцан ашигтай хамтран ажиллах өргөн боломж, арга зам, үүд хаалга нь нээгдсэн юм. Энэнд хэд хэдэн хүчин зүйл зэрэгээр нөлөөлсөн нь мэдээж. Үүнд: юуны өмнө хоёр талын хүчин чармайлт, идэвхи санаачилга, хүсэл эрмэлзлэл зонхилох үүрэг гүйцэтгэсэн, хоёрт, тэр үеийн ЗХУ-ын нам төрийн удирдагчийн 1989 онд БНХАУ-д хийсэн айлчлал, түүний гол үр дүн нөлөөлсөн. Энэхүү айлчлал нь зөвхөн тухайн хоёр улсын харилцааг хэвийн болгосон төдийгүй 1989 оны олон улсын амьдралд онцгой чухал ач холбогдолтойд зүй ёсоор тооцогдох дэлхийн дахины томоохон үйл явдал болов. Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, эдийн засаг, цэргийн хүчин чадал, дэлхий дахинд үзүүлэх нөлөөгөөрөө асар их энэ хоёр том гүрэн харилцаагаа чингэж хэвийн болгож сайжруулахаар харилцан ойлголцож, итгэлцсэн нь тус хоёр орны хоорондын харилцаанд төдийгүй Ази, Номхон далайн бүс нутаг, дэлхийн энх тайван аюулгүй байдлын үйл хэрэгт чухал ач холбогдолтой болсон гэж үзэж болно. Үүний нэг илрэл нь олон мянган километр үргэлжилсэн хуучин ЗХУ, БНХАУ-ын хилийг энх тайван, найрамдлын хил болгохыг хоёр тал эрмэлзэж байгаагаар илэрхийлэхийн хамт БНХАУ армия 1 сая хүнээр цөөрүүлсэн бол ЗХУ нутгийнхээ Азийн хэсэг дэх ойр дунд тусгалын пуужингаа устгаж, зэвсэгт хүчнээ 1989-1990 онд үлэмж хувиар цөөрүүлэхээр харилцан тохирсон явдал юм. Үүнээс гадна дээрх арга хэмжээний хүрээнд 1987 онд Монгол орноос зөвлөлтийн цэргийн нэг дивиз, хэд хэдэн ангийг гаргаснаа нотлоод улмаар Зөвлөлт засгийн газар Монголын Засгийн газартай тохиролцсоны дагуу Зөвлөлтийн цэргийг 1989-1990 онд 75 хувиар хорогдуулан цаашид бүрэн гаргаж дуусгааа нотолжээ. Үүний баталгаа болгож уг айлчлал эхэлсэн тавдугаар сарын 15-ны өдөр Монголоос Зөвлөлтийн цэргийн ээлжит гаргалтыг зохион байгуулснаа зарлажээ. Энэ мэт алхам нь Монгол, Хятадын харилцааг хэвийн болгож сайжруулахад тодорхой тус дөхөм болсон юм. Гуравт; 90-ээд оны эхээр социалист систем нуран унаж, ЗХУ задарснаар олон улсын харилцаа хоёр туйлаас олон туйлд шилжиж, дэлхийн хэмжээний хүчний харьцаанд чанарын эрс өөрчлөлт гарав. Шинээр бүрэлдэн бий болж буй олон улсын дэг журамд Монгол, Хятад хоёр ч гадаад улс төрийн бодлогоо

шинээр тодорхойлох болсон нь манай орнуудын харилцаанд зохих тусгалаа олсон юм.

Манай хоёр улсын харилцааг хэвийн болгох, цаашид өргөжүүлэх үйлсэд төр засгийн тэргүүн нарын харилцан айлчлал, тэдгээрийн хооронд явагдсан илэн далангүй яриа хэлэлцээ, байгуулсан тодорхой гэрээ хэлэлцээрүүдийн үзэл санаа дорвитой хувь нэмэр оруулсан билээ. Тухайлбал, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн даргын 1990 онд БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлал, тэр айлчлалын үеэр Монгол, Хятадын засгийн газрын хооронд шийжлэх ухаан-техник, байгаль, орчин, эрүүлийг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрүүд байгуулж, тус хоёр улсын хилийг энх тайвны хил болгох, хил залгаа нутгийн иргэд харилцан зорчих, бараа солилцоог нэмэгдүүлэхэд тус дөхөм үзүүлэх, манай улсад жижиг, дунд үйлдвэр байгуулах талаар хамтран ажиллах, монголын тал Хятадын нутгаар дамжин далайд гарах эрхийг хэрэгжүүлэх зэрэг худалдаа, хамтын ажиллагааны асуудлыг тодорхой шийдэхээр тохиролцсон нь чухал ач холбогдолтой болов.

БНХАУ-ын даргын 1991 онд Монгол улсад хийсэн албан ёсны айлчлал ч чухал үр дүнтэй болсныг хоёр тал санал нэгтэй тэмдэглэжээ. Энэхүү айлчлалын үеэр "Монгол улс Хятад улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай", "Татварыг давхар оногдуулахгүй байх", "Татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай", "Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай", "БНХАУ-ын Засгийн газраас БНМАУ-ын Засгийн газарт зээл олгох тухай" хоёр Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдэд болон БНХАУ-аас Монголд олгосон зээлийн өрийн төлбөрийн хугацааг хойшлуулах тухай солилцох захидалд тус тус гарын үсэг зуржээ.

Төрийн тэргүүн нарын дээрх харилцан айлчлал нь сүүлийн хорь гаруй жил тасалдсан дээд хэмжээний уулзалтыг шинээр дахин сэргээсэн үйл явдал болсноороо онцлог юм.

1992 онд Монгол улсын Засгийн газрын Ерөнхий сайд БНХАУ-д сүүлийн 30 жилд анх удаа албан ёсны айлчлал хийсэн нь хоёр орны харилцааг бүх салбарт хөгжүүлэх, ялангуяа эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн өргөтгөхөд томхон түлхэц болов.

Монгол Улсын ерөнхий сайд Пунцагийн Жасрайн урилгаар БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Ли Пэн 1994 оны 4 дүгээр сарын 28-29-нд Монгол улсад албан ёсоор айлчлав.

Монгол Улсын ерөнхийлөгч, Улсын их хурлын дарга нар ерөнхий сайд Ли Пэнг тус тус хүлээн авч уулзав. Ерөнхий сайд П.Жасрай, Ли Пэн нар хэлэлцээ хийв.

Уулзалт яриа, хэлэлцээний үеэр хоёр тал өөр өөрийн орны дотоод байдал, гадаад бодлогын талаар харилцан мэдээлж, Монгол Хятадын харилцааг, цаашид хөгжүүлэх болон олон улсын харилцан сонирхсон асуудлаар санал солилцов. Чин сэтгэлийн найрсаг байдалд болсон яриа хэлэлцээ хоёр тал олон асуудлаар санал нэг байгааг харуулав.

Айлчлалын үеэр "Монгол улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ" Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд соёлын салбарт хамтран ажиллах тухай, Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай, Хилийн усыг хамгаалах болон ашиглах тухай, Мал, амьтны хорио цээр, болон мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай, экспорт, импортын барааны чанарыг баталгаажуулах, харилцан зөвшөөрөх талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр зэрэг баримт бичигт гарын үсэг зурав.

1960 онд байгуулсан БНМАУ, БНХАУ,-ын найрамдал, харилцан туслалцах тухай Гэрээ хоёр улсын харилцааг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд түүнийг үндэслэж шинэчлэн байгуулсан Монгол улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ хоёр улсын сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааны ирээдүйн хөгжлийн эрх зүйн шинэ баталгаа болж, хоёр улсын харилцааны үндсэн зарчим, хэм хэмжээг тодорхойллоо гэж хоёр тал санал нэгтэй тэмдэглэв.

Хятадын тал Монгол Улсын тусгаар тогтнол, төрийн бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал болон цөмийн зэвсэггүй бүсийн статусыг хүндэтгэж байгаагаа дахин нотлов. Гадаадын цэрэг, цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй, түүнийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхгүй байхад чиглэсэн Монгол улсын бодлогыг БНХАУ хүндэтгэн үзэж байгаагаа илэрхийлэв. Монголын тал БНХАУ-ын Засгийн газар бол Хятад улсыг төлөөлсөн хууль ёсны цорын ганц Засгийн газар бөгөөд Тайвань бол БНХАУ-ын нутаг дэвсгэрийн салшгүй хэсэг мөн гэж үзэж байгаагаа дахин нотлов.

Түүнчлэн 1994 оны намар Монгол Улсын Их Хурлын дарга тэргүүтэй УИХ-ын төлөөлөгчдийн БНХАУ-д, 1997 оны 4 дүгээр сард Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга Цяо Ши-гийн Монгол улсад хийсэн албан ёсны айлчлалууд амжилттай болсон нь тус хоёр орны харилцаанд гарч буй нааштай чухал өөрчлөлтийн нэг илрэл мөн гэж үзвэл зохино.

Тухайлбал, Монгол улсын УИХ-ын даргын айлчлалын үеэр болсон хэлэлцээний явцад Хятадын удирдлага Монгол Улстай харилцах харилцааны зарчмыг таван зүйл дээр тодорхойлж ярьсан байна. БНХАУ тодорхойлохдоо:

Нэгд, Энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр Монгол, Хятадын харилцааг XXI зуунд чиглүүлэх; хоёрт, хоёр орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, сонгосон замыг нь харилцан хүндэтгэнэ; гуравт, эрх тэгш, харилцан ашигтай ажиллах зарчмын үндсэн дээр эдийн засаг худалдааны хүрээнд тус дэмжлэг үзүүлнэ; дөрөвт, Зүүн Азийн бүс нутагт бат бэх энх тайван, тогтвортой байдлыг хангахад Монгол Улсаас оруулсан хувь нэмрийг бид үнэлж байна. Өөрийн нутаг дэвсгэр дээр цөмийн зэвсэг болон үй олноор хөнөөх зэвсэг байрлуулахгүй байх Монгол Улсын санааг БНХАУ бүрэн дүүрэн дэмжиж байна; тавд, Монгол орныг бусад оронтой сайнаар харилцахыг БНХАУ талархан дэмжинэ гэж мэдэгджээ<sup>6</sup>.

1996 оны гуравдугаар сарын 27-30-нд Монгол Улсын Ерөнхий сайд Пунцагийн Жасрай БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Ли Пэний урилгаар БНХАУ-д албан ёсоор айлчлав.

Бээжинд явагдсан энэхүү уулзалт яриа, хэлэлцээнүүдийн үеэр Монгол, Хятадын сайн хөршийн найрсаг харилцаа, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр болон Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай 1994 оны Гэрээний үзэл санааны дагуу цаашид урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх нь Монгол, Хятадын ард түмний язгуур эрх ашигт бүрэн нийцэж, Ази, Номхон далайн энх тайван, тогтвортой байдлын хөгжилд тус дөхөм үзүүлнэ гэж талууд санал нэгтэй тэмдэглэсэн байна<sup>7</sup>.

Талууд Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд тууштай өргөжин хөгжиж байгааг болон өнөөгийн

хүрээнд байгаа энэ бааз суурь дээр хамтын ажиллагааг өргөтгөн гүнзгийрүүлэх, мөн шинэ арга хэлбэрийг тасралтгүй эрж хайх замаар худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг улам өндөр түвшинд хүргэхэд түлхэц өгөхийн чухлыг онцлон тэмдэглэв. Яриа хэлэлцээний явцад, хятадын агаарын коридорыг ашиглахад Монголын талд Хятад улс тааламжтай нөхцөл олгохоор болсон бөгөөд Монголын Таван толгойн коксжих нүүрсний ордыг олон талаар ашиглах асуудлаар хоёр тал санал солилцож, үргэлжлүүлэн ярилцахаар тохиролцжээ. Мөн хоёр тал Зүүн хойт Азийн бүс нутгийн эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжиж, энх тайван, тогтвортой байдлыг нь хангахад хүчин чармайлтаа дайчлахын төлөө байгаагаа илэрхийлэн Хятадын тал АПЕК, түүний ажлын хэсгүүдэд оролцох монголын талын хүсэлтийг дэмжиж ажиллахаар болжээ.

Айлчлалын үеэр БНХАУ-ын Засгийн газар Монгол Улсад 20 сая юанийн буцалтгүй тусламж олгох тухай, эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр, хоёр улсын боловсролын болон соёлын салбарт хамтран ажиллах төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдэд гарын үсэг зурав.

Монголын төлөөлөгчид Далянь хотод зочилж, БНХАУ-ын өөрчлөн байгуулалт, нээлттэй эдийн засгийн ололт амжилттай танилцсан нь Зүүн хойт Азид хоёр орон хамтран ажиллах өргөн боломж буйг нотлов. Тийнхүү хоёр орны хооронд сүүлийн жилүүдэд дээд болон өндөр хэмжээний удирдагчдын айлчлал, уулзалт, яриа хэлэлцээ уламжлал болон тогтож, тэдгээрийн харилцан ойлголцол, итгэлцэл бэхжиж улс төрийн таатай нөхцөл байдал бүрэлдэж байгаа нь юуны урьд эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжин хөгжих чухал хөшүүрэг, хүчин зүйл болж буй юм.

Чухамдаа БНХАУ, Монгол Улс хоёр нь мөнхийн хөрш орны хувьд эдийн засаг, худалдааны гол түншүүд ямагт байсан, ба байгаа бөгөөд энэ нь аль алины эрх ашигт бүрэн нийцэж байна.

Сүүлийн гурван жилд худалдаа илүү их идэвхжиж 1993 онд худалдааны нийт эргэлт 172.4 сая ам. долларт хүрч 1990 оныхоос 2.6 дахин өссөн нь үүний нэг тод жишээ мөн<sup>9</sup>.

Монголын эдийн засаг чөлөөт зах зээлд шилжих тусам гадаад худалдаа улам либеральчлагдаж Засгийн газрын шугамаар импортлодог хүнс, өргөн хэрэгцээний барааны нэр төрөл, тоо хэмжээ үлэмж цөөрсөөр байна. Энэ нь Монгол, Хятадын худалдаанд ч ажиглагдаж байна. Манайх 1990 онд Хятадаас 10 гаруй нэр төрлийн хүнсний бараа, 30 шахам нэр төрлийн өргөн хэрэгцээний бараа, 10 орчим нэр төрлийн үйлдвэрлэл техникийн зориулалттай бараа тус тус импортлож байсан бол 1992 онд цай, саахар, цагаан будаа, гурил даалимба, бэржээх, 1993 онд зөвхөн цай, гурил, бага хэмжээний даалимба бэржээх импортлов<sup>10</sup>.

90-ээд оны эхэн хүртэл Хятадтай болон бусад оронтой Монголын хийх худалдааг үндсэндээ Засгийн газраас төвлөрүүлэн зохицуулж бараа солилцооны журмаар явуулж ирсэн байна.

Тухайлбал, 1951-1979 онд мал, мап аж ахуй болон амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, 1980-1990 онд мөн дээрх төрлийн бүтээгдэхүүн, мод, зүсмэл, цемент, 1991-1993 онд зэсийн баяжмал Засгийн газрын зохицуулалтаар нийлүүлж гол төлөв хүнс, өргөн хэрэгцээний бараа авч байв. Манайхаас олон арван жилийн турш нийлүүлж буй экспортын барааны дийлэнх хувь нь анхан шатны боловсруулалт ч хийгээгүй түүхий эд, материал хэлбэрээр хямд төсөр үнэлэгдэн гарч байгаа билээ. Харин Хятадаас авч ирсэн уламжлалт бараа нь

бүхэлдээ шинжлэх ухаан, техникийн ололт, хөдөлмөр бага шингэсэн хүнс, өргөн хэрэгцээний энгийн зүйлс бөгөөд дотооддоо үйлдвэрлэгдэх өртөг нь хямд учир Хятадын хувьд багагүй ашигтай экспорт хийгдэж буй талтай.

Сүүлийн хэдэн жилд чөлөөт зах зээлийн шинж нөхцөл байдал бий болж байгаатай уялдан Засгийн газруудын тохиролцоогоор сольж буй бараанаас гадна хил худалдаа, бараа солилцоогоор үлэмж хэмжээний бараа харилцан авч өгдөг практик нэвтэрч байна. Бараа солилцоо нь бүхэлдээ монголын хувьд төдийлөн ашигтай хэлбэр биш боловч цаашид улам идэвхжиж байгаа нь харагдаж байна. Тус хоёр улсын харилцан нийлүүлж буй барааны чанарын асуудал өнөөдөр чухлаар тавигдаж Засгийн газруудын хэмжээнд авч үзэх, тусгай шийдвэр гаргахад хүргэв. Хятадаас чанарын болон эрүүл ахуйн шаардлага хангахгүй үндэсний зан заншилд үл нийцэх бараа, ялангуяа хүнсний зүйлүүд оруулсаар байгаагаас гадна Монголын пүүс, компаниудын нийлүүлж буй бараа, түүхий эд, материалын бэлтгэлийн чанар муугаас бас багагүй маргаан гарч, хоёр талын түншүүд их, бага хохирол хүлээсээр байна. Энэнд нэг зүйлийг зориуд хэлэхэд монголчуудын өөрсдийн нь тодорхой бодлого чиглэлгүй, эмх замбараа, тооцоо судалгаагүй, бас дэг журам сахилгагүй байдал, хилийн худалдаа явуулах бэлтгэл, мэдлэг, соёлгүй байдал ихээхэн нөлөөлсөн ба нөлөөлж буй болно. Түүнчлэн монгол хүмүүсийн монголоон, эх орноон гэсэн эрхэм сэтгэл ихэд үгүйлэгдэж байгаа нь илтэд мэдрэгдэж байгаа билээ.

Бас монголын экспортлогчдын хувьд өөрийн орны болон Хятадын холбогдох хууль, дүрэм, журмыг сайн мэддэггүйгээс гадна худалдаа наймааны туршлага багатай учир хожихоосоо алдах нь их байна. Зарим тохиолдолд бараагаа нийлүүлээд төлбөрөө авч чаддаггүй, эсвэл төлбөрөө хийчихээд бараагаа ч авч чаддаггүй явдал гарсаар байна. Энэ нь аж ахуйн маргаан гаргахад хүргэж, Монгол, Хятадын байгууллагуудын аль аль нь шийдвэрлэж чадахгүй олон сараар үргэлжилсэн будлиан үүсгэх нь ч бий.

Барааны чанарын асуудлыг эс шийдвэл худалдаа хэвийн хөгжих, харилцан ашигтай өргөжихэд сөргөөр нөлөөлөх нь тодорхой. Харин 1994 онд Хятадын Засгийн газартай байгуулсан "Харилцан нийлүүлж буй барааны чанарыг баталгаажуулах, харилцан хүлээн зөвшөөрөх талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр" дээрх амаргүй асуудлыг цэгцлэхэд түлхэц болох учиртай.

Үүнээс гадна худалдааг харилцан ашигтай өргөжүүлэхэд Монгол, Хятадын хоорондын тээвэр, харилцаа холбоо чухал үүрэгтэй болох нь улам бүр мэдрэгдсээр байна. Хоёр орны хоорондын ачаа тээвэр өнөөдөр зөвхөн төмөр замаар хязгаарлагдаж байгаа бөгөөд тэр нь хүчин чадлын хувьд төдийлөн өндөр бус байгаа юм.

Хоёр орны хооронд авто тээврийн үйлчилгээ бий болгох асуудлыг удаа дараа хөндөж янз бүрийн санал монголын талаас тавьсаар байгаа боловч үр дүнд хараахан хүрээгүй л байна. Автотээврийн салбарт хамтран ажиллах гэрээг Засгийн газрууд байгуулсан боловч хэрэгжүүлэх ажил урагштай биш байна.

Далайн тээврийн хамтарсан компани байгуулж улс хооронд ачаа тээх төлөвлөгөө одоохондоо цаасан дээр хэвээр байна. Энэ нь хөрөнгө чадлаа огоорон хоосон наймаалцдаг бидний зантай бас холбоотой. Монгол улсын хувьд Орос, Хятадын хооронд транзит тээвэр ашигтай хийх боломжоо ч муу ашиглаж байгаа нь харамсалтай. Транзит тээврийн орлогоор зээлийн болон импортын төлбөрийн зарим хэсгийг

хааж ирсэн туршлага ч сүүлийн жилүүдэд мартагдаж эхлэв.

Орос, Хятадын худалдаа улам өргөжиж буй өнөөгийн нөхцөлд транзит тээврийг сэргээх, цаашид нэмэгдүүлэх нь Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн харилцааг идэвхжүүлэх чухал хүчин зүйлийн хувьд нь манай засгийн газрууд онцгойлон анхаарч 1994 оны хавар холбогдох үнэ тарифийг бууруулах харилцан хөнгөлөл үзүүлэх талаар тохиролцсон нь олон талын ач холбогдолтой алхам болсон юм.

Харилцаа холбооны хувьд ч гэсэн зөвхөн Улаанбаатар-Бээжингийн хооронд л шууд харьцах боломжтой байгаа нь мэдээж хангалтай биш юм. Манай бусад аймаг хот Хятадын мужууд болон томоохон хотуудтай шууд холбоогүй байгаа нь худалдаа, бусад бизнесийн мэдээ, мэдээлэл шуурхай солилцох, гэрээ хэлэлцээ хийхэд хүндрэлтэй байгаа билээ.

Хөрш хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааны нөгөө нэг тулгамдсан асуудал бол худалдааны төлбөр болон өр юм. Монгол Улс 1990 оны худалдааны тэнцлээр Хятадад 5.8 сая швейцарь франкийн өглөгтэй<sup>11</sup> гарсан бөгөөд түүнийг барагдуулах эцсийн тохиролцоонд бас сайн хүрээгүй л байна. Үүнээс гадна 1993 оны импортын төлбөрийн үлдэгдэл 3.7 сая ам доллар Монголын "Эрдэнэт, "Разноимпекс" хэмээх хоёр том концерны дунд эзэнгүй хэвээр байна. Нэгэнт авч хэрэглэсэн барааны төлбөрийг ийнхүү он дамжуулан төлөхгүй унжих нь түншийхээ итгэлийг алдаж улсыг өрөнд нэмж оруулах замыг тавьсаар байгаатай адил юм<sup>12</sup>.

Үүнтэй холбогдон манай хоёр орны худалдаанд тулгарч буй өөр нэг чухал зүйл бол төлбөр, түүнийг гүйцэтгэх валютын тухай асуудал юм. Худалдааг олон жилийн турш шилжих, рубль, үндэсний валют, швейцарь франкаар хийж ирсэн бөгөөд 1991 оноос америк долларт шилжив. Монгол төгрөг Хятадын юаньтай харьцах ханш өнөөдөр тодорхой бус байна.

1994 он гарсаар Хятад улс юаныхаа чөлөөт валюттай харьцах ханшийг нэгтгэн чөлөөлж улмаар түүнийг ойрын 6 жилд чөлөөтэй хөрвөдөг болгох зорилт тавилаа. Энэ нь хэтдээ тус хоёр орны худалдаа хийх валютыг дахин авч үзэхэд хүргэж болзошгүй болов.

Худалдааны төлбөр тооцоо хийх валютын асуудал нь Монгол Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хэвийн явагдахад тодорхой хэмжээний сөрөг нөлөө үзүүлсээр иржээ.

Манай хоёр орны төв болон арилжааны банкууд хоорондын харилцаа, үйлчилгээ, хамтын ажиллагаа төдийлөн тогтворжоогүй байгаа нь эдийн засгийн харилцаа хэвийн явагдах, өргөжихөд мэдээж сайнаар нөлөөлөхгүй байгаа билээ.

Манай хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа 1990-ээд он гарсаар сэргэж мэдэгдэхүйц өргөжиж байгаагийн дотор Хятадын Засгийн газраас олгож буй хөнгөлөлттэй зээлийг ашиглан хэрэгжүүлэх төслүүд чухал байр суурийг эзэлж байна. БНХАУ-ын Засгийн газраас 1991, 1992 онд олгосон нийт 80 сая юанийн зээлээс цардуулын үйлдвэр барьж ашиглалтад оруулснаас гадна нэлээд хэмжээний цай даалимба авч өргөн хэрэгцээнд нийлүүлжээ.

Түүнчлэн цаасны үйлдвэр барих зураг төслийн гэрээ, Төмөр замын бетон дэрний үйлдвэрийн төслийг санхүүжүүлэх талаар хэлэлцээ хийж, тодорхой тохиролцоонд хүрээд одоо хэрэгжиж байна<sup>13</sup>.

Мөн улсын хэмжээний томоохон төслийн хувьд авч үзвэл Монголын Таван толгойн коксжих нүүрс, Төмөр толгойн төмрийн хүдрийн ордыг хамтран ашиглах, Улаанбаатар-Бээжинг автозамаар холбох, Замын-Үүд,

Эрээний орчинд худалдааны чөлөөт бүс байгуулах, Монгол Хятадын худалдааны төвийг Улаанбаатарт байгуулах зэрэг саналыг янз бүрийн түвшинд ярилцаж зохих тохиролцоонд хүрээд хэрэгжих шатандаа ороод байна.

Монгол орон байгалийн баялаг, түүний нөөцийн хувьд Хятадтай зэрэгцэхгүй ч гэсэн их хол зөрөхгүй билээ. Гэвч ажиллах хүчин, капиталын нөөц, технологи, менежментийн хувьд Хятадаас эрс ялгаатай. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн орон зайд Хятад нь монголоос олон дахин илүү нөөц чадавхитай айл юм. Энд ганц жишээг л дурьдахад Хятад улс 1994 онд 200 тэрбум ам долларын гадаад худалдаа хийснээс 105 тэрбум нь экспорт ажээ. Мөн 1991-1995 онд 500 тэрбум ам долларын технологи, тоног төхөөрөмж түүхий эд, материал импортлох төлөвлөгөө хэрэгжүүлсэн байна<sup>14</sup>.

Монгол улс Хятадын хувьд том зах зээл биш боловч хөршийн хувьд байнгын түнш билээ. БНХАУ Монголын гадаад худалдаанд хоёрдугаар байр буюу гадаад худалдааны нийт эргэлтийн 24 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ хувь цаашид өсөн нэмэгдэх төлөвтэй байна. Түүнчлэн хөрөнгө оруулалт, пүүс, компанитай хамтарсан хэлбэрээр байгуулж буй аж ахуйн нэгжийн тоогоор мөн хоёрдугаар байранд орж байна. Сүүлийн үед хоёр улсын хамтын ажиллагаа идэвхжиж, хилийн болон бүс нутгийн хоорондын худалдаа нэлээн өсч байна.

Монгол улсын эдийн засаг урьдын адил импортоос ихээхэн хамааралтай хэвээр бөгөөд түүний ихэнхийг байгалиас заяасан хоёр их хөршөөсөө одоо ч цаашид ч авах нь маргаангүй.

Монгол, Хятадын хамтын ажиллагаа нь өөр бусад салбарт тухайлан иргэний агаарын тээвэр, гааль, зам харилцаа, шуудан холбоо, боловсрол, эрүүлийг хамгаалал, соёл, шинжлэх ухааны зэрэг салбарт жар, далаад оны үеийн тасалдсан, зогсонги байдлыг бодвол ахицтай, урагштай байгааг тэмдэглэвэл зохилтой. Гэхдээ санасан хүссэн хэмжээнд, өнөөгийн зохих шаардлагын түвшинд буюу олзуурхам үр дүнд хараахан хүрээгүй байна.

Гэвч дээр өгүүлсэн зарим зохисгүй явдал зэрэг нь хоёр орны харилцааг өнөөгийн шинэ нөхцөлд илүү үр ашигтай, улам өөдрөгөөр хөгжүүлж урагшлуулахад онцгой саад бэрхшээл болохгүй юм. Гагцхүү хоёр улсын үндэсний эрх ашгийг харилцан жинхэнэ ёсоор дээдэлж, харилцаа, хамтын ажиллагааны арга хэлбэр, үр ашгийг өнөөгийн шинэ үзэл санаанд тохируулан дээшлүүлж өөрөөр хэлбэл "өнгөрсөнөө түүхийн хуудаснаа үлдээн хааж ирээдүйгээ цоо шинээр сэтгэж нээн харах" шаардлага зүй ёсоор тавигдаж байгааг бодитойгоор авч үзэж хамтын хүч чармайлт гаргах хэрэгтэй байна. Ингэх нь чухам үнэндээ мөнхийн хөрш манай хоёр орны төдийгүй, улмаар бүс нутгийн тухайлан зүүн хойт Азийн тогтвортой аюулгүй байдлыг ханган бэхжүүлэх олон талын хамтын ажиллагааны эрх ашиг, үйлсэд чухал хувь нэмэр болохсон бөлгөө.

Зүүлт

1. "Ертөнцийн товчоон: тоо баримт, мэдээлэл", УБ., 1996, 474-р талд
2. Мөн тэнд.
3. "Ардын төр", 1988, №2
4. "Ардын эрх", 1994, №158
5. Мөн тэнд.
6. "Ардын эрх", 1994, №195
7. "Засгийн газрын мэдээ, 1994, №261
8. Мөн тэнд.